



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/234

Мандалговь

“Мастертөсөл” ХХК-тай гэрээ байгуулах тухай<sup>1</sup>

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 33 дугаар зүйл 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Д.Чагдаржавын талбайн тохижилтын зураг, төсөв” боловсруулах зөвлөх үйлчилгээний ажилд ирүүлсэн үнийн саналаар “Мастертөсөл” ХХК-тай 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зургийн даалгаврын дагуу Д.Чагдаржавын талбайн тохижилтын зураг, төсөв боловсруулах ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Мастертөсөл” ХХК-ний дэд захирал (Л.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Сайнцагаан сумын Засаг дарга, Мандалговь хотын захирагч (С.Бат-Оргил), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4862111-1